

**ДАРХАН-СЭЛЭНГИЙН БҮСЭД ХАР ТӨМӨРЛӨГИЙН ЦОГЦОЛБОРЫГ ДЭД БҮТЦИЙН
ХАМТ БАЙГУУЛАХ ТӨСӨЛ**

ТӨСЛИЙН ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	
1. Төслийн нэр, хүчин чадал:	“Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”
2. Төсөл хэрэгжих салбар, дэд салбар:	Хүнд үйлдвэр. Төмөрлөгийн үйлдвэрлэл
3. Төслийн хэрэгжих хугацаа:	2016 – 2019 он
4. Төслийн төсөвт өртөг /сая ам.доллар/:	800
5. Хэрэгжүүлэгч яам, байгууллага:	“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХК
ТӨСЛИЙН ТАЛААРХ НАРИЙВЧИЛСАН МЭДЭЭЛЭЛ	
6. Байршил:	Дархан Уул аймаг, Дархан сум
7. Бүтээгдэхүүн:	-Үндсэн бүтээгдэхүүн: Жилд 350,0 мян.тн ган туйван, ган утас, ган бөмбөлөг -Дагалдах бүтээгдэхүүн: Жилд 500,0 мян.тн цувимал ган, аргалж /pellets/
8. Төслийн үндэслэл:	-Аж үйлдвэрийн сайдын 2016 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилтот хөтөлбөр” -Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр.
9. Төслийн зорилго:	Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дотоодын ган цувимал бүтээгдэхүүний хэрэгцээг хангах, валютын гадагшлах урсгалыг багасгах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагасан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд төслийн зорилго оршино.
10. Төслийн техникийн баримт бичиг боловсруулсан байдал:	Төслийн Техник-эдийн засгийн үндэслэлийг Дэлхийн банкны “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр Канад улсын “Hatch” компани, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг Монгол улсын “Экотон компаниуд” гүйцэтгэж байгаа ба ТЭЗҮ болон БОНБНҮ-ний эцсийн тайланг 2017 оны 4 дүгээр сард хүлээж авна.
11. Хүрэх үр дүн:	-Монгол улс дотооддоо үйлдвэрлэсэн ган, цувимал бүтээгдэхүүнээр өөрийгөө бүрэн хангаж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч орон болно. -Үйлдвэрлэлд байгаль орчин, нийгэмд аюулгүй техник, технологи нэвтэрнэ. -Импортыг орлох бүтээгдэхүүний нэр төрлийг шинээр бий болгосноор манай улсын гадаад

	<p>худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлнэ.</p> <p>-Орон нутагт 800 шууд ажлын байр шинээр бий болгоно.</p>
--	--